

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** САГ-2026/72/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2025 он

Санхүүгийн аудитын газрын захирал,  
Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261665 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер: А.Цогбаяр  
Утас: 261663 Цахим хаяг: [tsogbayara@audit.gov.mn](mailto:tsogbayara@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Ариунжаргал  
Утас: 261740 Цахим хаяг: [ariunjargalb@audit.gov.mn](mailto:ariunjargalb@audit.gov.mn)

Аудитор: Г.Өсөхжаргал  
Утас: 261740 Цахим хаяг: [usukhjargalq@audit.gov.mn](mailto:usukhjargalq@audit.gov.mn)

Аудитор: Д.Номингуа  
Утас: 261740 Цахим хаяг: [nominguad@audit.gov.mn](mailto:nominguad@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	14
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	18
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	18
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	18
3.5.3 Нэмэлт төсөв.....	20
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	21
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	22
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	22
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	22
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	23
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	23
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	25
4.5.1 Завсрын аудитын талаар.....	25
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	25
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	26
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	27
5.1 Албан шаардлага .....	27
5.3 Зөвлөмж .....	31
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	32

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ГБХНХС	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
САГ	Санхүүгийн аудитын газар
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТББ	Төрийн бус байгууллага
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОУ	Олон улс
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ӨХБЗ	Өмч хамгаалах байнгын зөвлөл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь, хүний орлогын албан татвар
ХНХ	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА Л.МӨНХЗУЛ ТАНАА

2026.02.25 № 06/310  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 930,688.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тайлант онд нийт 319,082.5 мянган төгрөгийн ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн;
- Үндсэн чиг үүрэг бүхий ажлуудыг аж ахуйн нэгж, хувь хүнтэй гэрээ байгуулан нийт 114,800.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон ч үр дүнг тооцоогүй, дүгнэлт, тайлан гаргаагүй, батлагдсан төсөвт тусгагдаагүй ажил үйлчилгээг санхүүжүүлж, нийт 131,470.1 мянган төгрөгөөр төсвийг үрэлгэн зарцуулсан;
- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар нийт 35,810.1 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн, зардлын эдийн засгийн ангилал зөрчиж 76,068.7 мянган төгрөгийг зарцуулсан;
- Гэрээний үүргийн биелэлт хангалтгүй байхад ажлын тайланг хүлээн авч, нийт 64,500.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон, үйл ажиллагааны чиглэл нь өөр аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан 56,030.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон зэрэг зөрчлүүд илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаал баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-ын холбогдох заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн "ангилал", "нийцсэн ба зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Засгийн газрын 2025 оны "Хөрөнгө гаргах тухай" 208, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 40, "Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 41 дүгээр тогтоолуудаар Хөвсгөл аймгийн "Шинэ мөрөн" төвийн худалдаа эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэхэд зориулж 5,200,000.0 мянган төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 4,862,889.0 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт шилжүүлсэн.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт үндэсний хорооны 2022 оны 27 дугаар тогтоолын дагуу Үндэсний хорооны зөвлөлийн гишүүд, Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Тусгай сургалтын байгууллагын зардал тооцох, зарим албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох журам"-ын 2.5 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм"-ийн 6.2 дахь хэсгийг үндэслэн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын аймаг, дүүргийн салбар комиссын гишүүд, нийт 1,034 хүнд /давхардсан тоогоор/ 499,100.3 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Засгийн газрын 2025 оны "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" 07 дугаар тогтоолын дагуу Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн "Бүтэц орон тоо шинэчлэн батлах тухай" А/218 дугаар тушаалаар яамны бүтцийг 7 газар, 5 хэлтэс, нийт 125 орон тоотой болгож, 9 хувиар бууруулан баталсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	424,680,885.62	1,454,271,076.13
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	52,086,321.62	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	52,086,321.62	-
3121	Төгрөг	52,086,321.62	-
31217	Төрийн сангийн харилцах	52,086,321.62	
33	АВЛАГА	57,416,595.00	38,825,214.71
33300	Татаас, санхүүжилтийн авлага	52,516,595.00	15,630,000.00
335	Бусад авлага	4,900,000.00	23,195,214.71
3351	Байгууллагаас авах авлага	4,900,000.00	23,195,214.71
34	УРЬДЧИЛГАА	-	505,600,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	505,600,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	98,162,119.00	56,517,211.42
354	Хангамжийн материал	98,162,119.00	56,517,211.42
35410	Бичиг хэргийн материал	8,888,300.00	979,500.00
35420	Аж ахуйн материал	23,331,680.00	12,258,830.00
35430	Сэлбэг хэрэгсэл	15,175,000.00	3,256,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,000,000.00	1,859,291.42
35470	Бусад хангамжийн материал	49,767,139.00	38,163,590.00
36	НӨӨЦИЙН БАРАА	217,015,850.00	853,328,650.00
36900	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	217,015,850.00	853,328,650.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,924,035,597.71	6,219,888,608.57
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,924,035,597.71	6,219,888,608.57
392	Биет хөрөнгө	4,884,821,118.76	5,510,987,912.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,003,962,236.00	4,343,004,902.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(559,880,846.46)	(661,871,049.01)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	360,833,000.00	340,835,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(132,858,222.40)	(139,843,722.44)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,731,255,793.64	2,463,685,947.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	(881,988,490.11)	(1,257,663,493.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	623,618,727.50	582,160,322.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(321,397,447.37)	(222,096,361.93)
39214	Бусад үндсэн хөрөнгө	62,665,861.00	64,165,861.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,133,293.04)	(2,133,293.04)
39217	Ном	743,800.00	743,800.00
393	Биет бус хөрөнгө	1,039,214,478.95	708,900,695.75
39301	Програм хангамж	1,018,804,500.00	1,018,804,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(207,332,911.05)	(537,646,694.25)
39303	Бусад биет бус хөрөнгө	227,742,890.00	227,742,890.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>6,348,716,483.33</b>	<b>7,674,159,684.70</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,348,716,483.33	7,674,159,684.70
51	Засгийн газрын хувь оролцоо	6,348,716,483.33	7,674,159,684.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	769,507,340.00	769,507,340.00
51101	Өмч: - төрийн	769,507,340.00	769,507,340.00
512	Хуримтлагдсан үр дүн	5,132,139,745.37	6,457,582,946.74
51210	Өмнөх үеийн үр дүн	4,314,723,777.94	5,132,139,745.37
51220	Тайлант үеийн үр дүн	817,415,967.43	1,325,443,201.37
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	447,069,397.96	447,069,397.96
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>6,348,716,483.33</b>	<b>7,674,159,684.70</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>59,924,588,154.00</b>	<b>63,521,955,640.10</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,044,514,664.00	63,521,955,640.10
120	Нийтлэг татварын бус орлого	2,044,514,664.00	1,642,395,127.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	102,160,626.00	974,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	102,160,626.00	974,800.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,942,354,038.00	995,495,914.68
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	645,924,412.42
122	Тусламжийн орлого	-	61,879,560,513.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	61,879,560,513.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	56,190,921,990.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	56,190,921,990.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	5,688,638,523.00
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	167,617,400.00
122133	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,521,021,123.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	57,880,073,490.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	56,018,958,617.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	56,018,958,617.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,861,114,873.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	488,576,071.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,372,538,802.00	-
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>56,972,028,849.17</b>	<b>62,196,454,822.06</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	56,972,028,849.17	62,196,454,822.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,875,163,311.69	16,271,636,639.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,164,342,622.33	6,252,155,372.76
210101	Үндсэн цалин	3,082,814,863.63	3,067,529,951.98
210102	Нэмэгдэл	1,351,430,774.45	1,203,269,091.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	696,770,495.24	762,154,518.50
210104	Урамшуулал	917,193,689.01	1,219,201,811.11
210105	Гэрээт ажлын хөлс	116,132,800.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	683,636,333.84	710,827,456.37
210201	Тэтгэврийн даатгалын зардал	469,297,905.40	494,527,023.77
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	55,650,148.70	56,164,848.05
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	27,664,505.00	27,942,431.47
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	25,942,860.58	26,438,630.67
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	105,080,914.16	105,754,522.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	183,027,150.00	236,925,300.00
210301	Гэрэл, цахилгаан	94,881,200.00	127,371,000.00
210302	Түлш, халаалт	57,467,340.00	88,294,100.00
210303	Цэвэр, бохир ус	20,814,410.00	21,260,200.00
210304	Байрны түрээс	9,864,200.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	506,489,216.06	307,834,201.78
210401	Бичиг хэрэг	212,673,884.00	67,099,820.00
210402	Тээвэр, шатахуун	24,498,516.00	37,201,041.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	50,388,438.36	45,311,302.28
210404	Ном, хэвлэл	92,899,000.00	47,730,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	126,029,377.70	110,492,038.50
2105	Нормативт зардал	78,888,377.37	-
210502	Хоол, хүнс	49,506,378.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	29,381,999.37	-

**Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,671,948.00	60,550,167.10
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,755,500.00	380,000.00
210604	Урсгал засвар	36,916,448.00	60,170,167.10
2107	Томилолт, зочны зардал	385,467,987.62	268,862,770.53
210701	Гадаад албан томилолт	198,085,137.62	149,088,450.53
210702	Дотоод албан томилолт	187,382,850.00	119,774,320.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,542,823,465.00	1,809,058,284.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,495,940,184.00	1,748,107,056.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,848,382.00	5,720.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	399,324.00	1,853,011.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	36,759,257.00	57,686,500.00
210807	Газрын төлбөр	5,799,318.00	1,405,997.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,289,816,211.47	6,625,423,087.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,124,559,579.00	5,539,645,529.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	443,691,719.00	39,947,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	721,564,913.47	1,045,830,458.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,096,865,537.48	45,924,818,182.37
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	9,419,058,389.34	45,506,867,792.42
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	9,242,897,636.12	45,452,900,887.42
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	186,679,887.42
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	58,811,713.42
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\	-	127,868,174.00
213114	Төсөв хоорондын шилжүүлэг	-	45,266,221,000.00
2131143	Цаатан иргэдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн зардал \УТ-НДС\	-	146,575,400.00
2131144	УТ-с төлөх ХАЧХТДС-н тэтгэврийн даатгалын шимтгэлийн зардал \УТ-НДС\	-	45,119,645,600.00
213101	Бусад засгийн газрын дотоод шилжүүлэг	9,242,897,636.12	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	176,160,753.22	53,966,905.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,961,793,900.00	417,170,068.33
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	34,809,663,900.00	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,350,000.00	19,650,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	316,656,068.33
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	138,780,000.00	80,864,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	716,013,248.14	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	707,491,124.14	-
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	8,522,124.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	780,321.62
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	780,321.62
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>2,952,559,304.83</b>	<b>1,325,500,818.04</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,135,143,337.40</b>	<b>57,616.67</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	3,233,333.40	57,616.67
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	742,064,400.00	-
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалтай хөрөнгийн зардал	1,389,845,604.00	-
<b>VII</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)</b>	<b>(2,135,143,337.40)</b>	<b>(57,616.67)</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>	<b>817,415,967.43</b>	<b>1,325,443,201.37</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>769,507,340.00</b>	<b>447,069,397.96</b>	<b>4,314,723,777.94</b>	<b>5,531,300,515.90</b>
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	769,507,340.00	447,069,397.96	4,314,723,777.94	5,531,300,515.90
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	817,415,967.43	817,415,967.43
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>769,507,340.00</b>	<b>447,069,397.96</b>	<b>5,132,139,745.37</b>	<b>6,348,716,483.33</b>
<b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>769,507,340.00</b>	<b>447,069,397.96</b>	<b>5,132,139,745.37</b>	<b>6,348,716,483.33</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	769,507,340.00	447,069,397.96	5,132,139,745.37	6,348,716,483.33
Тайлант үеийн үр дүн	-	-	1,325,443,201.37	1,325,443,201.37
<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>769,507,340.00</b>	<b>447,069,397.96</b>	<b>6,457,582,946.74</b>	<b>7,674,159,684.70</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>57,990,054,554.00</b>	<b>61,933,051,908.00</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	102,160,626.00	61,933,051,908.00
120	Нийтлэг татварын бус орлого	102,160,626.00	974,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	102,160,626.00	974,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	102,160,626.00	974,800.00
122	Тусламжийн орлого	-	61,932,077,108.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	61,932,077,108.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	56,190,921,990.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	56,190,921,990.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	5,741,155,118.00
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	220,133,995.00
122133	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,521,021,123.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	57,887,893,928.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	56,018,958,617.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	56,018,958,617.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,868,935,311.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	496,396,509.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,372,538,802.00	-
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>57,559,917,006.50</b>	<b>61,638,893,058.62</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	57,559,917,006.50	61,638,893,058.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,410,534,874.02	15,698,444,876.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,100,094,389.04	6,255,120,504.47
210101	Үндсэн цалин	2,514,730,499.69	3,067,529,951.98
210102	Нэмэгдэл	2,111,658,300.34	1,203,269,091.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	603,563,700.00	762,154,518.50
210104	Урамшуулал	766,609,089.01	1,222,166,942.82
210105	Гэрээт ажлын хөлс	103,532,800.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	682,051,266.74	710,827,456.37
210201	Тэтгэврийн даатгалын зардал	469,971,070.95	494,527,023.77
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	54,986,770.53	56,164,848.05
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	27,239,402.47	27,942,431.47
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	25,836,584.95	26,438,630.67
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	104,017,437.84	105,754,522.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	183,027,150.00	236,925,300.00
210301	Гэрэл, цахилгаан	94,881,200.00	127,371,000.00
210302	Түлш, халаалт	57,467,340.00	88,294,100.00
210303	Цэвэр, бохир ус	20,814,410.00	21,260,200.00
210304	Байрны түрээс	9,864,200.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	245,654,768.37	269,123,764.78
210401	Бичиг хэрэг	89,297,224.00	67,099,820.00
210402	Тээвэр, шатахуун	29,568,516.00	37,067,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	50,388,438.37	45,311,302.28
210404	Ном, хэвлэл	2,700,000.00	47,730,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	73,700,590.00	71,915,642.50
2105	Нормативт зардал	49,506,378.00	-
210502	Хоол, хүнс	49,506,378.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	97,859,519.50	63,334,167.10
210601	Багаж, техник, хэрэгсэл	23,879,570.00	3,164,000.00
210604	Урсгал засвар	73,979,949.50	60,170,167.10

**Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2107	Томилолт, зочны зардал	373,869,987.62	268,862,770.53
210701	Гадаад албан томилолт	196,857,137.62	149,088,450.53
210702	Дотоод албан томилолт	177,012,850.00	119,774,320.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,636,366,765.38	2,314,658,284.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,589,303,484.38	1,748,107,056.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,848,382.00	5,720.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	399,324.00	1,853,011.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	36,939,257.00	563,286,500.00
210807	Газрын төлбөр	5,799,318.00	1,405,997.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,042,104,649.37	5,579,592,629.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,567,077,880.37	5,539,645,529.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	475,026,769.00	39,947,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,149,382,132.48	45,940,448,182.37
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	9,419,058,389.34	45,522,497,792.42
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	9,242,897,636.12	45,468,530,887.42
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн сауруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	202,309,887.42
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	58,811,713.42
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\	-	127,868,174.00
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	15,630,000.00
213114	Төсөв хоорондын шилжүүлэг	-	45,266,221,000.00
2131143	Цаатан иргэдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн зардал \УТ-НДС\	-	146,575,400.00
2131144	УТ-с төлөх ХАЧХТДС-н тэтгэврийн даатгалын шимтгэлийн зардал \УТ-НДС\	-	45,119,645,600.00
213101	Бусад засгийн газрын дотоод шилжүүлэг	9,242,897,636.12	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	176,160,753.22	53,966,905.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,961,793,900.00	417,170,068.33
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	34,809,663,900.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,350,000.00	19,650,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	316,656,068.33
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	138,780,000.00	80,864,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	768,529,843.14	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	707,491,124.14	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	52,516,595.00	-
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	8,522,124.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	780,321.62
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	780,321.62
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	430,137,547.50	294,158,849.38
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	413,437,547.50	346,245,171.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	413,437,547.50	346,245,171.00
2200	Дотоод эх үүсвэрээр	413,437,547.50	346,245,171.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	413,437,547.50	346,245,171.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(413,437,547.50)</b>	<b>(346,245,171.00)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>16,700,000.00</b>	<b>(52,086,321.62)</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	35,386,321.62	52,086,321.62
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	52,086,321.62	-

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>59,816,456,800.00</b>	<b>56,133,085,076.58</b>	<b>3,683,371,723.42</b>	<b>93.8</b>
Татварын бус орлого		974,800.00	(974,800.00)	
Улсын төсвөөс санхүүжих	59,816,456,800.00	56,132,110,276.58	3,684,646,523.42	93.8
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>59,816,456,800.00</b>	<b>56,133,085,076.58</b>	<b>3,683,371,723.42</b>	<b>93.8</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	59,816,456,800.00	56,133,085,076.58	3,683,371,723.42	93.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,937,067,900.00	10,421,227,103.25	3,515,840,796.75	74.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,752,040,500.00	6,255,120,504.47	496,919,995.53	92.6
Үндсэн цалин	3,253,645,700.00	3,067,529,951.98	186,115,748.02	94.3
Нэмэгдэл	1,344,666,500.00	1,203,269,091.17	141,397,408.83	89.5
Унаа хоолны хөнгөлөлт	909,585,400.00	762,154,518.50	147,430,881.50	83.8
Урамшуулал	1,244,142,900.00	1,222,166,942.82	21,975,957.18	98.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	773,275,600.00	710,827,456.37	62,448,143.63	91.9
Тэтгэврийн даатгал	526,421,800.00	494,527,023.77	31,894,776.23	93.9
Тэтгэмжийн даатгал	61,778,500.00	56,164,848.05	5,613,651.95	90.9
ҮОМШӨ-ний даатгал	30,882,200.00	27,942,431.47	2,939,768.53	90.5
Ажилгүйдлийн даатгал	30,838,600.00	26,438,630.67	4,399,969.33	85.7
Эрүүл мэндийн даатгал	123,354,500.00	105,754,522.41	17,599,977.59	85.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	236,925,300.00	236,925,300.00	-	100.0
Гэрэл, цахилгаан	127,371,000.00	127,371,000.00	-	100.0
Түлш, халаалт	88,294,100.00	88,294,100.00	-	100.0
Цэвэр, бохир ус	21,260,200.00	21,260,200.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	331,270,600.00	266,620,764.78	64,649,835.22	80.5
Бичиг хэрэг	82,648,000.00	64,099,820.00	18,548,180.00	77.6
Тээвэр, шатахуун	55,022,900.00	36,563,000.00	18,459,900.00	66.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	61,042,100.00	45,311,302.28	15,730,797.72	74.2
Ном, хэвлэл	47,730,000.00	47,730,000.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	84,827,600.00	72,916,642.50	11,910,957.50	86.0
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>605,411,500.00</b>	<b>408,578,338.10</b>	<b>196,833,161.90</b>	<b>67.5</b>
Багаж, техник, хэрэгсэл	9,365,500.00	9,365,505.00	(5.00)	100.0
Урсгал засвар	596,046,000.00	399,212,833.10	196,833,166.90	67.0
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>286,150,900.00</b>	<b>260,632,770.53</b>	<b>25,518,129.47</b>	<b>91.1</b>
Гадаад албан томилолт	149,914,900.00	149,088,450.53	826,449.47	99.4
Дотоод албан томилолт	136,236,000.00	111,544,320.00	24,691,680.00	81.9
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,800,061,600.00</b>	<b>2,141,284,884.00</b>	<b>2,658,776,716.00</b>	<b>44.6</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,516,720,700.00	1,574,733,656.00	941,987,044.00	62.6
Даатгалын үйлчилгээ	3,583,800.00	5,720.00	3,578,080.00	0.2
Тээврийн хэрэгслийн татвар	2,298,000.00	1,853,011.00	444,989.00	80.6
Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,400.00	-	88,400.00	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,270,490,800.00	563,286,500.00	1,707,204,300.00	24.8
Газрын төлбөр	6,879,900.00	1,405,997.00	5,473,903.00	20.4
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>151,931,900.00</b>	<b>141,237,085.00</b>	<b>10,694,815.00</b>	<b>93.0</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	111,984,800.00	101,289,985.00	10,694,815.00	90.4
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	39,947,100.00	39,947,100.00	-	100.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>45,879,388,900.00</b>	<b>45,711,857,973.33</b>	<b>167,530,926.67</b>	<b>99.6</b>
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>8,173,197,500.00</b>	<b>8,062,092,305.00</b>	<b>111,105,195.00</b>	<b>98.6</b>
Засгийн газрын дотоод шилжүүлэг	8,008,125,400.00	8,008,125,400.00	-	100.0

**Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Засгийн газрын гадаад шилжүүлэг	165,072,100.00	53,966,905.00	111,105,195.00	32.7
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>37,706,191,400.00</b>	<b>37,649,765,668.33</b>	<b>56,425,731.67</b>	<b>99.9</b>
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	37,258,095,600.00	37,258,095,600.00	-	100.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	19,950,000.00	19,650,000.00	300,000.00	98.5
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	333,145,800.00	316,656,068.33	16,489,731.67	95.1
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	95,000,000.00	55,364,000.00	39,636,000.00	58.3
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	
<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>52,086,321.62</b>	<b>(52,086,321.62)</b>	<b>-</b>
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>125</b>	<b>125</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Удирдах ажилтан	11	11	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	108	108	-	100.0
Үйлчлэх ажилтан	6	6	-	100.0
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>125</b>	<b>125</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	111	111	-	100.0
Ажлын албаны албан хаагч (АА)	1	1	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11	11	-	100.0
Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	-	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I.	<b>ОРЛОГЫН ДҮН</b>	<b>5,741,155,118.00</b>
II.	<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>5,741,155,118.00</b>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,741,155,118.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,741,155,118.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	220,133,995.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,521,021,123.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,741,155,118.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,741,155,118.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,597,656,944.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,504,000.00
210401	Бичиг хэрэг	3,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	504,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,230,000.00
210702	Дотоод албан томилолт	8,230,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	173,373,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	173,373,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,412,549,544.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,412,549,544.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	143,498,174.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	143,498,174.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	143,498,174.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрхэм зорилгыг “Гэр бүл, хүн амын хөгжил, хөдөлмөр, нийгмийн хамгааллын харилцан уялдаатай цогц бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж, иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин бий болгох, нийгмийн баталгааг дээшлүүлэх замаар хүний хөгжлийг хангахад оршино.” гэж тодорхойлжээ.

Эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг хэрэгжүүлж ажилласан байна. Тухайлбал:

- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, яамны үйл ажиллагаанд хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж сурталчлах, сургалт зохион байгуулах, гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх, яамны санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах;
- Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлж, хүн амын бүлгүүдийн хөгжил, оролцоог хангах, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, нийгмийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн салбар дундын гэр бүлд ээлтэй цогц бодлого боловсруулж, хүн амын тогтвортой өсөлт, гэр бүл, хүний хөгжлийг дэмжих;
- Хөдөлмөрийн зах зээлийн зөв, оновчтой бодлого боловсруулж, гэр бүлд ээлтэй, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн харилцааг төлөвшүүлэх, хөдөлмөрийн хууль тогтоомж, цалин хөлсний бодлого зохицуулалтыг боловсронгуй болгох, хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт болон бусад хамтын ажиллагааг хангах, салбарын хууль тогтоомж, норм, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд хяналт тавих;
- Нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хүн амын насны бүтцийн хэтийн төлөвийг харгалзсан нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг эрчимжүүлэх, нийгмийн даатгалын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах;
- Нийгмийн халамжийн үйлчилгээний хууль эрх орчныг шинэчилж, боловсронгуй болгох, нийгмийн халамжийн үйлчилгээ, асаргааны хувилбарт үйлчилгээг хөгжүүлж, хувийн хэвшил, орон нутаг, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, зорилтот бүлэгт чиглүүлэх замаар нийгмийн халамж, үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх;
- Салбарын хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөр боловсруулахад судалгаа, шинжилгээ, бодлогын удирдамжаар хангах, салбарын санхүү, эдийн засгийн болон хөрөнгө оруулалтын урт, дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, хуулийн төсөл, төсөв боловсруулах, батлуулах, хөрөнгө оруулалт, төсвийн шинжилгээ хийх, салбар хоорондын уялдаа, бодлогын хэрэгжилтийг хангах, батлагдсан төсвийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, төрийн сангийн үйл ажиллагааг эрхлэх;

Тайлант оны онцлог үйл явдлууд:

- Засгийн газрын баталсан 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын үндсэн цалинг 6 хувиар нэмэгдүүлж, төрийн захиргааны болон төрийн мэргэжлийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээ 1,166.0 мянган төгрөг, төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээ 954.0 төгрөг болсон;
- Тэтгэврийн тухай хуульд заасны дагуу Засгийн газрын 2024 оны 221 дүгээр тогтоолоор цэргийн тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлсэн. Энэ арга хэмжээнд нийт 505.6 мянган тэтгэвэр авагч хамрагдаж, тэтгэврийн нэмэгдэлд нийт 300,000,000.0 мянган төгрөг зарцуулсан;
- Ахмад настны тухай хуулийн 8.1.3-т заасны дагуу Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/186 дугаар тушаалаар “Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам”-ыг шинэчлэн баталсан;

- Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 117 дугаар тогтоолоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт олгох журам”-ыг батлуулсан;

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг үндэслэн боловсруулж, стратегийн бодлогын зорилт, үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний үндсэн чиглэлийг тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль;
- Нийгмийн халамжийн тухай;
- Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай;
- Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай;
- Үндэсний баялгийн сангийн тухай хууль;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам;
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгавар, 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгавар.

Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тайлант хугацаанд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны санхүүгийн үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2017 онд батлагдсан, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Монгол Улсын Сангийн Сайдын тушаалаар баталсан журам, заавар, аргачлалын дагуу шинэчлэл хийгдээгүй.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэжээ.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,325,443.2 мянган төгрөгөөр буюу 20.0 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	52,086.3	-	(52,086.3)
Авлага	57,416.6	38,825.2	(18,591.4)
Урьдчилгаа	-	505,600.0	(505,600.0)
Бараа материал	98,162.1	56,517.2	(41,644.9)
Эргэлтийн бус хөрөнгө	217,015.9	853,328.7	636,312.8
Үндсэн хөрөнгө	5,924,035.6	6,219,888.6	295,853.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>6,348,716.5</b>	<b>7,674,159.7</b>	<b>1,325,443.2</b>
Засгийн газрын хувь оролцоо	6,348,716.5	7,674,159.7	1,325,443.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>6,348,716.5</b>	<b>7,674,159.7</b>	<b>1,325,443.2</b>

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансууд байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 52,086.3 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны Ахмадын санд төвлөрүүлсэн үлдэгдлийг зарцуулсантай холбоотой;
- Авлага дансны үлдэгдэл 38,825.2 мянган төгрөг болж, 18,591.4 мянган төгрөгөөр буурсан нь татаас санхүүжилтийн авлага 52,516.6 мянган төгрөгөөр буурч, тайлант оны татаас санхүүжилтийн авлага 15,630.0 мянган төгрөгөөр, АШУҮИС-ийн нийгмийн эрүүл мэндийн сургуультай байгуулсан “Ажил гүйцэтгэх гэрээ”-нд тусгасан ажил хийгдээгүйгээс 15,330.1 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 2,965.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдснээс голлон нөлөөлсөн;
- Урьдчилгаа дансны үлдэгдэл 505,600.0 мянган төгрөг байгаа нь “Өгөгдлийн шинжилгээний үйл ажиллагаа” зөвлөх үйлчилгээний урьдчилгаа төлбөрийг олгосноос шалтгаалсан байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 56,517.2 мянган төгрөг болж, 41,644.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд худалдан авсан 684,880.0 мянган төгрөгийн бичиг хэрэг, аж ахуй, сэлбэг хэрэгсэл, түлш, шатахуун, барилгын засварын материал, хүнсний материал, бусад хангамжийн материалаар нэмэгдэж, 726,524.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой;
- Борлуулах зориулалтаар эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгө 636,312.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Залуучуудын хөгжлийн төвийн барилгын /Налайх дүүрэг/ гүүрний зориулалтай барилга, байгууламж барих ажлын зураг, төслийг нэмж бүртгэсэнтэй холбоотой байна.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 6,219,888.6 мянган төгрөг болж, 295,853.0 мянган төгрөгөөр өссөн нь:
  - Тайлант онд төсвийн хөрөнгөөр 346,245.2 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн;
  - ТӨБЗГ-ын 2025 оны 325, 666 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 335,741.0 мянган төгрөгийн хөрөнгийн өртгийг 167,870.5 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон;
  - ТӨБЗГ-ын 2025 оны 475 дугаар тогтоолоор татан буулгах зарим үндэсний хороодын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 40,413.5 мянган төгрөгийн балансын үнэ, 5,179.7 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авсан;

- ГБХНХСайдын 2025 оны “Хөрөнгийн хуваарилалт батлах тухай” А/131 тоот тушаалын дагуу ГБХНХамгааллын салбарын их өгөгдөл, цахим шилжилт, тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ төсөл арга хэмжээний хүрээнд нийлүүлэгдсэн 794,151.6 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэж, тайлант хугацаанд 1,045,830.5 мянган төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 7,674,159.7 мянган төгрөг болж, 1,325,443.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны санхүүгийн үр дүнгээс шалтгаалжээ.

Программ хангамжийн талаарх судалгаа авахад 1,018,804.5 мянган төгрөгийн үнэ бүхий 12 программыг байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байна.

Судалгаанд нэгтгэгдсэн программ хангамжууд нь үндсэн хөрөнгийн дансны программ хангамжийн ангилалд бүртгэлтэй, санхүүгийн нэгтгэлийн болон санхүүгийн үйл ажиллагааны “Аксplorер” программыг жил бүр 1,100.0 мянган төгрөгөөр сунгуулан ашигладаг, тус программ хангамж нь ТЕЗ-ийн ерөнхий нягтлан бодогч, яамны санхүүгийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, эд хариуцагч нар ашиглаж байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.2-д заасны дагуу төсвийн шууд захирагчийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 60,850,497.6 мянган төгрөгөөр, урсгал үйл ажиллагааны зардлыг 60,850,497.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн урсгал үйл ажиллагааны зардлыг 53,028.2 мянган төгрөгөөр бууруулж, төсвийг 60,797,469.4 мянган төгрөгөөр баталжээ. Тухайлбал: Төсвийн хязгаарт батлагдаагүй нормативт зардлыг 40,000.0 мянган төгрөгөөр төлөвлөснийг батлаагүй, төсвийн хязгаараас давсан бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардлыг 13,028.2 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна.

Батлагдсан төсвийн 61.3 хувь буюу 37,258,095.6 мянган төгрөгийг нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмжийн /засгийн газрын урсгал шилжүүлэг/ зардал эзэлж байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 981,012.6 мянган төгрөгөөр бууруулж, 59,816,456.8 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийн 20 арга хэмжээнд 59,816,456.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 56,190,921.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 974.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 56,133,085.0 мянган төгрөг буюу 93.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 3,683,371.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна. Тухайлбал: цалин, хөлсний зардал 496,919.9 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл 62,448.1 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 64,649.8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 196,833.2 мянган төгрөг, томилт зочны зардал 25,518.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 2,658,776.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 10,694.8 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 167,530.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Код	Нэр				
	НИЙТ		59,816,456.8	56,133,085.0	3,683,371.8	93.8
1	71901	Нийгмийн даатгал	45,266,221.0	45,266,221.0	-	100.0
1.1	80612	Нийгмийн даатгалын бусад	37,258,095.6	37,258,095.6	-	100.0

**Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

1.2	80615	Эхчүүдийн нийгмийн даатгалын шимтгэл	7,271,550.0	7,271,550.0	-	100.0
1.3	80824	Цэргийн албан хааж байсан иргэдийн НДШ	590,000.0	590,000.0	-	100.0
1.4	80831	Цааган иргэдийн НДШ	146,575.4	146,575.4	-	100.0
<b>2</b>	<b>71902</b>	<b>Нийгмийн халамж</b>	<b>19,950.0</b>	<b>19,650.0</b>	<b>300.0</b>	<b>98.5</b>
2.1	80704	Ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж	19,950.0	19,650.0	300.0	98.5
<b>3</b>	<b>71903</b>	<b>Нийгмийн хамгааллын бодлого удирдлага</b>	<b>12,583,817.5</b>	<b>9,677,714.1</b>	<b>2,906,103.4</b>	<b>76.9</b>
3.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	10,764,232.6	8,187,100.8	2,577,431.8	76.0
3.2	80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	222,333.4	210,030.5	12,302.9	94.5
3.3	80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	237,899.8	236,687.2	1,212.6	99.5
3.4	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	579,477.0	491,251.8	88,225.2	84.8
3.5	80509	Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	165,072.1	53,966.9	111,105.2	32.7
3.7	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	428,145.8	372,020.0	56,125.8	86.9
3.8	81520	Олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулах	7,984.8	7,984.7	0.1	99.9
3.9	82614	Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа хөтөлбөр	178,672.0	118,672.0	60,000.0	66.4
<b>4</b>	<b>72206</b>	<b>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгаалал</b>	<b>1,244,710.5</b>	<b>661,186.0</b>	<b>583,524.5</b>	<b>53.1</b>
4.1	80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	472,230.0	470,648.8	1,581.2	99.7
4.2	80725	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээ	772,480.5	190,537.2	581,943.3	24.7
<b>5</b>	<b>72207</b>	<b>Хүүхдийн хөгжил, хамгаалал</b>	<b>199,196.6</b>	<b>19,718.6</b>	<b>179,478.0</b>	<b>9.9</b>
5.1	80238	Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	159,379.4	19,718.6	139,660.8	12.4
5.2	80240	Хүүхдийн хөгжил оролцоо	39,817.2	0	39,817.0	0
<b>6</b>	<b>72208</b>	<b>Ахмад настны хөгжил хамгаалал</b>	<b>278,310.0</b>	<b>275,000.0</b>	<b>3,310.0</b>	<b>98.8</b>
6.1	80103	Гэрээгээр гүйцэтгэх ажил, үйлчилгээ	278,310.0	275,000.0	3,310.0	98.8
<b>7</b>	<b>72212</b>	<b>Гэр бүлийн хөгжил хамгаалал</b>	<b>224,251.2</b>	<b>213,595.2</b>	<b>10,655.0</b>	<b>79.9</b>
7.1	80103	Гэрээгээр гүйцэтгэх ажил, үйлчилгээ	53,000.0	42,345.0	10,655.0	79.9
7.2	83115	Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүд	171,251.2	171,250.2	1.0	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

1. Байгууллагын орон тооны цомхотголын талаар: “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгаж оновчтой болгох, төрийн үйлчилгээний цахимжилтыг эрчимжүүлэх, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-нд туссан багш, эмч нараас бусад төрийн албан хаагчийг орон тоог 9 хувиар бууруулах арга хэмжээг авсан.

ГБХНХЯ-ны ТНБД-ын 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн “Бүтэц орон тоо шинэчлэн батлах тухай” А/18 дугаар тушаалаар яамны албан хаагчдын тоог 137 байснаас 125 болгон, 12 орон тоогоор бууруулан баталжээ. Тайлант оны 8 дугаар сар хүртэлх хугацааны гүйцэтгэлээр дунджаар 116 албан хаагч ажиллаж, орон тоо шинэчлэн баталсан тушаалын хүрээнд албан тушаал нь хасагдсан 2 албан хаагчийг цомхотгон нийт 12,906.0 мянган

төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, 5 албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарч 316,656.0 мянган төгрөгийн тэтгэмжийг тус тус олгожээ. Тэтгэвэрт гарсан албан хаагчдын орон тоонд нэмж албан хаагч томилоогүй байна.

2. ГБХНХЯ-ны ТНБД-ын 2024 оны А/74 дүгээр тушаалаар албан хаагчдын ажлын нэг өдрийн хоолны мөнгийг 25.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлтийг 3.0 мянган төгрөгөөр баталсан, тайлант онд хоол, унааны хөнгөлөлтийн хэмжээнд өөрчлөлт ороогүй байна. Тайлант онд хоол, унааны зардалд нийт 909,585.4 мянган төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 762,154.5 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 147,430.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулжээ.
3. Гадаад томилолтын зардалд нийт 149,914.9 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 149,088.4 мянган төгрөгийг тайлагнасан. Аудитаар анхан шатны бүрдэл дутуу баримтаар 10,991.5 мянган төгрөгийн томилолтын зардал олгосон, 10,406.0 мянган төгрөгийн гадаад томилолтын зардлыг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас эдийн засгийн ангилал зөрчин зарцуулжээ.
4. Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 39,947.1 мянган төгрөгийг баталснаас тайлант хугацаанд бүрэн зарцуулжээ. Тайлант онд 9 удаагийн сургалт зохион байгуулан нийт 811 хүн хамруулахаар төлөвлөж, сургалтыг бүрэн зохион байгуулсан байна.
5. Салбарын үйл ажиллагааг ярилцлага, мэдээ тодруулга, сурвалжлаг видео контент постер хэлбэрээр олон нийтэд сурталчлахад нийт 200,694.0 мянган төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 29 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан, 192,530.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.
6. Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагаанд тайлант онд төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал байхгүй болно.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

НҮБ-ын Хүн амын сангаас 71,556.6 мянган төгрөг, НҮБ-ын Хүүхдийн сангаас 51,467.4 мянган төгрөг, Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас 28,093.5 мянган төгрөг, Юнескогийн монголын үндэсний комиссоос 16,500.0 мянган төгрөг, Засгийн газрын нөөц сангаас Олон улсын Найрамдал цогцолборын засвар, шинэчлэлийн ажилд 658,132.1 мянган төгрөг, Засгийн газрын 2025 оны “Хөрөнгө гаргах тухай” 208, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 40, “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 41 дүгээр тогтоолуудаар Хөвсгөл аймгийн “Шинэ мөрөн” төвийн худалдаа эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэхэд 4,862,889.0 мянган төгрөг, татаас санхүүжилтийн авлага 52,516.5 мянган төгрөг, нийт 5,741,155.1 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, гүйцэтгэлээр хангамж бараа материалын зардалд 3,504.0 мянган төгрөг, томилолт зочны зардалд 8,230.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 173,373.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 5,412,549.5 мянган төгрөг, нийт 5,597,656.9 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

1. ТНБД-ын 2025 оны А/83 дугаар тушаалаар баталсан НҮБ-ын Хүн амын сантай 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний зардалд 71,537.4 мянган төгрөг;
2. ТНБД-ын 2025 оны А/305 дугаар тушаалын дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгааллын болон бусад журмын төсөл, Хүүхдийн эрхийн ахлах байцаагч, улсын байгуулахад 5,985.0 мянган төгрөг;
3. ЗГНСангаас санхүүжүүлсэн Олон Улсын Хүүхдийн найрамдал цогцолборын “Хараацай” театрын их засварын зардалд 549,660.5 мянган төгрөг;
4. ЗГНСангаас санхүүжүүлсэн Хөвсгөл аймгийн “Шинэ мөрөн” төвийн худалдаа эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэхэд 4,862,889.0 мянган төгрөг;
5. ОУХБ, ГБХНХЯам хооронд байгуулсан 40515132/0 дугаартай гэрээний 1.3 дахь хэсэгт заасан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг танилцуулах, хэлэлцүүлэхэд 23,530.4 мянган төгрөг;

6. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг чадавхжуулах төвийн бүсийн сургалтад 8,600.0 мянган төгрөг, бусад хэлэлцүүлэг сургалтын зардалд 75,454.6 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

Зарцуулаагүй үлдэгдэл 143,498.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлснээс 15,630.0 мянган төгрөгийг буцаан авахаар Сангийн яамны Төрийн сантай тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД нь төсвийн шууд захирагчийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 15 багц бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад нийт 2,937,742.0 мянган төгрөгийн төсвийг баталжээ.

Тайлант онд төсвийн үйл ажиллагааны худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөө, жагсаалтад өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 327,315.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн яам, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Тус яамны үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой төсвийн зарцуулалт, худалдан авах ажиллагаа, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Ариунжаргал, аудитор Г.Өсөжжаргал, аудитор Д.Номингуа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02/246 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болон үйл ажиллагааны бус зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болон үйл ажиллагааны бус зардал 57,926,001.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 579,260.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан горим сорил хэрэгжүүллээ. Санхүүгийн тайлангийн аудитаар тус яам нь 89,680.0 мянган төгрөгийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтад нийцүүлэлгүй зарцуулсан байна.

ГБХНХС-ын 2025 оны А/72 дугаар тушаалыг хэрэгжүүлэхдээ 7 аж ахуйн нэгжээс 82,163.5 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс бэлтгэсэн, дээрх үйл ажиллагааны урилга хэвлүүлэхэд 4,335.0 мянган төгрөг, мэндчилгээ хэвлүүлэхэд 2,182.0 мянган төгрөг, "Засгийн газрын цом-2025" спортын арга хэмжээнд зориулж спорт заалны түрээсийн төлбөрт 1,000.0 мянган төгрөг, нийт 89,680.0 мянган төгрөгөөр төсвийг үрэлгэн зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;", 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах." гэж заасныг тус тус зөрчиж байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй, төсвийн хэмнэлтийн бодлогыг баримталж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Нийцлийн аудиттай холбоотой нийт 302,079.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 302,079.0 мянган төгрөгийн зөрчил таслан зогсоох 3 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд байршуулбал зохих байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээллийг 2 удаа, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мөнгө зарцуулахтай холбоотой 97,598.5 мянган төгрөгийн 6 тушаалыг хугацаа хоцроож байршуулсан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна:", 3.1.1-д "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;", 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн мэдээлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитаар бусад хууль тогтоомжийн хүрээнд дараах зөрчил илэрлээ.Үүнд:

1. Засгийн газрын 2025 оны "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" 07 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт "Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-т заасан үндсэн чиг үүрэг бүхий ажлуудыг аж ахуй нэгж, хувь хүнтэй "Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ", "Ажил гүйцэтгэх гэрээ" байгуулан нийт 114,800.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон ч үр дүнг тооцоогүй, зөвлөх үйлчилгээ авсны давуу тал, тэдгээрээс гарсан бүтээгдэхүүнийг үйл ажиллагаандаа хэрхэн ашиглаж, нэвтрүүлж байгаа талаар дүгнэлт, тайлан гаргаагүй байна. Үүнд:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахтай холбогдуулан судалгаа, шинжилгээ хийж, ажлын хэсэгтэй хамтран ажиллах гэрээний дагуу 14,500.0 мянган төгрөг;
- ГБХНХСалбарын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны тухай, Хүүхэд хамгааллын тухай хууль, түүнтэй холбоотой шинээр боловсруулсан дүрэм журмын төслийг хянах зөвлөх үйлчилгээ үзүүлэх төлбөрт 9,000.0 мянган төгрөг;
- Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төсөл, төслийн бүрдүүлбэрийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу боловсруулах ажлын төлбөрт 14,400.0 мянган төгрөг;

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийн сангийн ажлын даалгавар боловсруулах зөвлөх үйлчилгээний төлбөрт 15,000.0 мянган төгрөг;
- Хуримтлалын сангийн мэдээллийн нэгдсэн системийн ерөнхий бүтцийн санал, санхүүгийн системийн иргэний хүсэлт, өргөдөл гомдол шийдвэрлэх системийн ажлын даалгавар гүйцэтгэх ажлын төлбөрт 15,000.0 мянган төгрөг;
- Гэр бүлийн цогц үйлчилгээний төвийн жишиг загвар төв байгуулах алхамчилсан зураглал боловсруулах, санал зөвлөмж гаргах ажлын хөлсөд 19,900.0 мянган төгрөг;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөний үнэлгээ болон хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх ажлын төлбөрт 15,000.0 мянган төгрөг;
- "Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай" 129 дүгээр конвенц, "Аж үйлдвэр, худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай" 147 оны 81 дүгээр конвенц, хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажлын төлбөрт 12,000.0 мянган төгрөгийг тус тус төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Засгийн газрын 2025 оны "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" 07 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт "Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-т тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөх ажил үйлчилгээний давуу тал болон үр дүнг тооцоогүй, тэдгээрээс гарсан бүтээгдэхүүнийг үйл ажиллагаандаа хэрхэн ашиглаж нэвтрүүлж байгаа талаар дүгнэлт тайлан гаргаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

2. Засгийн газрын 2025 оны "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" 07 дугаар тогтоолын дагуу ГБХНХЯ-ны ТНБД-ын 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн "Бүтэц орон тоо шинэчлэн батлах тухай" А/218 дугаар тушаалаар яамны бүтцийг 7 газар, 5 хэлтэс, нийт 125 орон тоотой болгож, 9 хувиар бууруулан баталсан ч хуучин бүтэц орон тоогоор 2025 оны 10 дугаар сарыг дуустал ажиллаж, цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 4,528,757.6 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2025 оны "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" 07 дугаар тогтоолын 9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн "Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" 04 дүгээр албан даалгаврын 1.2-т "төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гараагүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж нөхөн томилгоо хийхгүй байх...", ГБХНХЯ-ы Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн "Бүтэц орон тоо шинэчлэн батлах тухай" А/218 дугаар тушаалтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бүтэц, орон тоонд орсон өөрчлөлтийг батлагдсан хугацаанд нь хэрэгжүүлж, Засгийн газрын тогтоол, эрх бүхий албан тушаалтны тушаал, шийдвэрийн биелэлтэд тавих дотоод хяналтыг сайжруулах.

3. Төрийн аудитын байгууллагад 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу иж бүрэн ирүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54.5 дахь хэсэг "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна"-ийн 54.5.4-т "хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/, 54.5.5-д "нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, нэмэлт төсвийн гүйцэтгэл, хүрсэн үр дүн, тэдгээрийн танилцуулгыг бэлтгэж төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн тайлагнаж Төрийн аудитын байгууллагад ирүүлж байх.

4. ГБХНХЯам нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ 2017 оноос хойш хууль, тогтоомж, журамтай нийцүүлэн шинэчлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө.", Сангийн сайдын 2025 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/3 дугаар тушаалтай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулахдаа төсвийн зардал гаргахгүйгээр төсөв, санхүү хөрөнгө оруулалтын газрын эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн чиг үүргийг хариуцсан мэргэжилтнүүдээр холбогдох хууль, журмын дагуу шинэчлэлийг хийлгэж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

ГБХНХЯ-ны 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар нийт 726,823.9 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах талаар 4 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг жилийн эцсийн нэгтгэн дүгнэж, хэрэгжилтийг үнэлэхэд дараах байдалтай байна. Тухайлбал:

- Дотоод албан томилолтын зардалд 39,267.0 мянган төгрөгийн томилолтын хуудас, удирдамжгүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийсэн зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, баримтыг бүрдүүлсэн;
- Бараа материалын дансаар дамжуулалгүй 2,404.1 мянган төгрөгийг шууд зардалд бүртгэснийг залруулж, тус бараа материалыг орлогоор бүртгэсэн;
- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 364,228.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэх хүсэлтийг 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 02/4220 тоот албан бичгээр ТӨБЗГ-т хүргүүлсэн /ТӨБЗГ-ын 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 27 дугаар тогтоолоор шийдвэрлэгдсэн/;
- Яамны барилгын их засварын 308,424.7 мянган төгрөгийн зардлаар барилгыг капиталжуулж бүртгэсэн;
- Яамны дотоод ажил зохион байгуулагчийн үндсэн орон тоог бүтцийн өөрчлөлтөөр хассан боловч тус орон тоонд гэрээт ажилтан ажиллуулж, нийт 12,500.0 төгрөгийн ажлын хөлс олгох "хөлсөөр ажиллуулах гэрээ" байгуулсан зөрчилд өгсөн зөвлөмжийн дагуу 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөр тасалбар болгон гэрээг цуцалсан байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6,324,646.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 12 албан шаардлагыг 90.2 биелүүлж, 5 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, биелэлт 96.7 хувьтай байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Хариуцлага тооцох албан шаардлага	1	-	1	-	100.0
Албан шаардлага	12	6,324,646.8	12	5,706,406.5	90.2
Зөвлөмж	5	948,962.1	5	948,962.1	100.0
<b>Нийт дүн</b>	<b>18</b>	<b>7,273,608.9</b>	<b>18</b>	<b>6,655,368.6</b>	<b>96.7</b>

Өмнөх аудитаар өгсөн Шилэн дансны цахим системд 5 саяас дүнтэй зарлагын 4,670,383.8 мянган төгрөгийн 35 гүйлгээг байршуулаагүй зөрчилд хүргүүлсэн албан шаардлагын хэрэгжүүлсэн

боловч тайлант онд байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээллийг 2 удаа, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мөнгө зарцуулахтай холбоотой 97,598.5 мянган төгрөгийн 6 тушаалыг хугацаа хоцроож мэдээлсэн.

Анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтын шаардлага хангаагүй нийт 98,079.7 мянган төгрөгийг бараа материалын дансаар дамжуулаагүй, шууд зардалд бүртгэсэн зөрчилд хүргүүлсэн албан шаардлагын биелэлт 63.5 хувийн биелэлттэй байна.

Тайлант онд хариуцсан албан хаагчид ажлаас чөлөөлөгдсөн тул давтан гарсан зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын хүүхдийн сан, Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас ГБХНХЯ-тай гэрээгээр хэрэгжүүлж буй Үндэсний шилжүүлгийн дансыг Монгол улсад ашиглах тухай хэлэлцүүлэг, Говийн бүсийн хүн амын хөгжлийн асуудлаар “Think tank” хэлэлцүүлэг, Жендерт суурилсан хүчирхийллийг бууруулах болон хяналт тавих талаар гол оролцогч талуудтай зохион байгуулсан уулзалт хэлэлцүүлэг, Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг, хүн ам зүй ба хөгжлийн Олон улсын 30 дахь хурлаас /CEDAW report/ гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хэсгийн уулзалтын хүрсэн үр дүн, хэрэгжилтэд түүврийн горим сорил хэрэгжүүлсэн ч цаг хугацааны хязгаарлагдмал нөхцөл байдлаас шалтгаалан хангалттай зохистой нотолгоо олж авах боломжгүй байсан тул дараагийн аудитаар үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 513,005.8 мянган төгрөгийн 6 алдаа<sup>1</sup> илрүүлснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ. Үүнд:

Залруулсан алдаа:

- Нийгмийн даатгалын шимтгэлийн 2,965.2 мянган төгрөгийн илүү төлөлтөөр авлага бүртгэхдээ ерөнхий журналд үндсэн цалингийн зардлыг бууруулсан;
- Тохируулах бичилтээр 450.0 мянган төгрөгийн худалдан авалтын өглөгийг шууд бичилтээр хаасныг бараа материалын дансанд орлогоор бүртгүүлсэн;
- Байгууллагад төлөх 1,895.0 мянган төгрөгийн өглөгийг мөнгөн гүйлгээ, санхүүгийн үр дүнгийн тайланд туслах үйл ажиллагааны орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэн, орлого бууруулах бичилт бичсэн;
- Үр дүнгийн тайланд туслах үйл ажиллагааны орлогыг 707.0 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжийн орлогыг 450.0 мянган төгрөгөөр тус тус илүү тайлагнасан;
- Машин тоног төхөөрөмжийн элэгдлийн зардлыг 938.6 мянган төгрөгөөр дутуу байгуулсан;
- Улсын төсвөөс санхүүжүүлсэн 637,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй "Өгөгдлийн шинжилгээний үйл ажиллагаа" зөвлөх үйлчилгээний урьдчилгаа төлбөр 505,600.0 мянган төгрөгийн мэдээлэл технологийн зардлыг шууд зардалд бүртгэсэн.

Эдгээр зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх," 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," гэж заасантай тус тус нийцэхгүй, УСННОУС-1 санхүүгийн тайлангийн толилуулгын 1.27, УСНББОУС-17 үндсэн хөрөнгийн 17.42 дахь параграф, санхүүгийн аудитын "оршин байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Санхүүгийн аудитаар нийт 726,208.3 мянган төгрөгийн 11 зөрчил<sup>2</sup> илэрснээс 692,975.8 мянган төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлж, 33,232.5 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 930,688.8 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 351,428.8 мянган төгрөгөөр их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. Үйл ажиллагааны чиглэл нь өөр аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулж нийт 56,030.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгожээ. Үүнд:

- Хөдөө аж ахуйн сэтгүүлчдийн ур чадвар, чадавхыг дээшлүүлэх, хөдөө аж ахуйн салбарын мэдээ, мэдээллийг мэргэжлийн түвшинд хүртээмжтэйгээр олон нийтэд сурталчлах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл бүхий нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагаас 980.0 мянган төгрөгийн дуу хураагуур худалдан авсан, мөн "Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдэлээс ангид байх, ёс зүйн, шударга байдлыг уриалсан агуулга бүхий видео контент" бэлтгэх ажлыг гэрээгээр гүйцэтгүүлж 12,000.0 мянган төгрөгийг олгосон;
- Төрийн албаны өдрийг угтан зохион байгуулсан Эрдэм шинжилгээний хуралд зориулж 5,200.0 мянган төгрөгөөр 371 ширхэг тараах материал бэлтгэн хэвлүүлэх ажлыг

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Хөгжлийн бэрхшээлтэй, хүнд өвчтэй хүүхдүүдэд болон асран хамгаалагч нарт сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, бүх талын туслалцаа, дэмжлэг үзүүлэх чиглэл бүхий аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлсэн;

- Хэвлэлийн үйл ажиллагаа эрхэлдэггүй аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, сургалтын тараах материал хэвлүүлэх зардалд 37,850.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” Гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үйл ажиллагааны чиглэл нь өөр аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан санхүүжилт олгодог зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. Анхан шатны бүрдэл дутуу баримтаар нийт 35,810.1 мянган төгрөгийн ажил үйлчилгээг бүртгэсэн байна. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 1 автотээврийн хэрэгсэлд 2025 оны 05 дугаар сард 23,255.6 мянган төгрөгийн засвар үйлчилгээг хийлгэсэн боловч Өмч хамгаалах зөвлөлийн хурлыг 2025 оны 11 дүгээр сард хуралдуулан шийдвэрийг засвар хийснээс хойш баталгаажуулсан;
- Хуулийн төслийг олон нийтэд сурталчлах, мэдээлэх, “салбарын мэргэжилтэн, сэтгүүлчдийн хооронд уулзалт зохион байгуулах гэрээ”-ний ерөнхий зүйлд заасан ажил, хавсралтад заасан ажил хоорондоо зөрүүтэй, гүйцэтгэсэн ажлын тайлангүй, гэрээ дүгнэсэн актгүй, үйл ажиллагааны чиглэл нь өөр аж ахуй нэгжид ажлын төлбөр 1,563.5 мянган төгрөгийг олгосон;
- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Томилолтоор ажиллуулах тухай” А/33 тоот тушаалын дагуу сайдын орон тооны зөвлөхийн Бүгд Найрамдах Солонгос Улс дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын төвийн үйл ажиллагаатай танилцах гадаад томилолтын зардалд зарцуулсан 10,991.5 мянган төгрөгийг анхан шатны баримт дутуу бүрдүүлж олгосон;

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “аж ахуйн нэгж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэж заасныг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант онд зардлын эдийн засгийн ангилал зөрчиж нийт 76,068.7 мянган төгрөгийг зарцуулжээ. Үүнд:

- ТНБД-ын 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн “Мөнгөн урамшуулал олгох тухай” А/206 дугаар тушаалаар нэр бүхий 17 ажилтанд салбарын эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажилд идэвх санаачилгатай ажилласан үндэслэлээр 41,507.0 мянган төгрөгийн шагналыг цалингийн зардлаас олгосон;
- Засгийн газрын байрны нийтлэг үйлчилгээний газартай байгуулсан гэрээгээр төлөх гэрэл цахилгаан, түлш халаалтын зардлын 14,882.2 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжаас төлсөн;
- Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс худалдан авах зардлаас 1,001.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн;

- ТНБД-ын 2025 оны А/69 дугаар тушаалын дагуу Бүгд Найрамдах Чех, Бүгд Найрамдах Польш улсад төрийн өндөр хэмжээний айлчлалын бүрэлдэхүүнд ажилласан албан хаагчдын гадаад томилолтын зардлын 8,000.0 мянган төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас, Катар улсын Доха хотод зохион байгуулагдсан Нийгмийн хөгжлийн төлөөх Дэлхийн дээд хэмжээний II дугаар уулзалтад оролцсон албан хаагчийн замын зардлын 2,406.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас зарцуулсан;
- Мэдээлэл технологийн зардлаас дэлгэцийн түрээс, суурилуулалтын зардалд 6,600.0 мянган төгрөгийг, гэрээт ажилтны цалингийн зардалд 1,672.5 мянган төгрөгийг тус тус эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;", Сангийн сайдын 2023 оны "Ангилал шинэчлэн батлах тухай" 211 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал", тавдугаар хавсралтын 2 дахь хэсэг "Урсгал зардлын ангиллын тайлбар"-ыг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зардлын эдийн засгийн ангилал зөрчин төсөв зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4. Батлагдсан төсөвт тусгагдаагүй ажил үйлчилгээг санхүүжүүлж, нийт 131,470.2 мянган төгрөгийн төсвийг үрэлгэн зарцуулсан. Үүнд:

- Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн "Гэр бүл хөгжил, хамгаалал хөтөлбөрөөс санхүүжих арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай" А/63 дугаар тушаалын хавсралтад өөрчлөлт оруулж, гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрчлэгчдэд сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор 2 сэтгэл зүйчид хөлсөөр ажиллуулах гэрээгээр байгуулж нийт 30,000.0 мянган төгрөгийн ажлын хөлс олгосон;
- Азийн хөгжлийн банкны "L3605/G9191:MON-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв"-ийн барилгын газар чөлөөлөхөд нэг иргэнд 18,691.2 мянган төгрөгийн нөхөн олговрыг олгосон;
- Монгол Улсад Хүүхдийн байгууллага, Хөдөлгөөн үүсэж, хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээнд зориулж, яамны үндсэн үйл ажиллагааны хөтөлбөр арга хэмжээнээс 82,779.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсөвт төлөвлөөгүй ажил үйлчилгээг санхүүжүүлж, төсвийг үрэлгэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5. Гэрээний үүргийн биелэлт хангалтгүй байхад ажлын тайланг хүлээн авч, нийт 64,500.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгож, төсвийг үрэлгэн зарцуулсан:

- Архивын улсын үзлэгт зориулан 19,500.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, гэрээнд 2019-2025 оныг дуусталх хугацааны 1,000 хадгаламжийн нэгжийг "Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгнө" гэж заасан боловч гэрээ гүйцэтгэсэн ажлын тайланд зөвхөн 2019, 2020 оны архивын баримтыг цэгцлэн хүлээлгэн өгч, 2021-2025 оны баримтыг хүлээлгэн өгөөгүй;
- Монгол Улсын 21 аймгийн хөгжлийн бэрхшээлтэй 630 хүүхдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар төлөвлөснөөс 378 хүүхдийг хамруулж, 252 хүүхдийг

хамруулаагүй байхад 19,900.0 мянган төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид бүрэн олгосон;

- Хуулийн этгээдтэй байгуулсан 5,500.0 мянган төгрөгийн өртөгтэй "Ажил гүйцэтгэх гэрээ"-нд гүйцэтгэгч байгууллагын хийх ажил тодорхойгүй, гүйцэтгэгчийн ажлын тайланд хийж гүйцэтгэсэн ажлын талаар тодорхой тусгаагүй;
- Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн "Хэлэлцүүлэг зохион байгуулах тухай" А/103 дугаар тушаалаар зохион байгуулсан "Хүүхдийн зуслангийн хөгжлийн бодлого, тогтолцооны шинэчлэл" хэлэлцүүлэгт зарцуулсан 19,600.0 мянган төгрөгийн гэрээт ажлын тайланд хүрсэн үр дүнг бодитой хэмжигдэхүйц байдлаар тайлагнаагүй, гаргасан шийдэл тодорхойгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасныг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний үүргийн биелэлт хангалтгүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийж төсвийг үрэлгэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

6.Тайлант хугацаанд бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоогүй 319,082.5 мянган төгрөгийн нэг төрлийн ижил бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийг хуваан шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн. Үүнд:

- Тайлан онд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийн хэлэлцүүлэг зохион байгуулах тухай " А/21 дүгээр тушаалын дагуу салбарын ажилтнуудад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг танилцуулж, санал авах, 2025 онд хэрэгжүүлэх Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнүүдийг танилцуулж, арга зүйн заавраар хангах хэлэлцүүлэг, сургалтыг зохион байгуулах ажилд 95,900.0 мянган төгрөгийн зарцуулж, нэг хуулийн этгээдээс шууд худалдан авалт хийсэн;
- Салбарын үйл ажиллагааг ярилцлага, мэдээ тодруулга, сурвалжлаг видео контент постер хэлбэрээр олон нийтэд сурталчлах ажлын зардал 192,530.5 мянган төгрөгийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлаагүй, тендер сонгон шалгаруулалт зохион байгуулалгүй батлагдсан төсөвт өртгийг хуваан тус бүр нь 4,900.0-18,000.0 мянган төгрөгөөр 29 хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй шууд гэрээ байгуулсан;
- Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн бэлтгэл ажлын зардал 30,652.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.", Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 2 дугаар тогтоолын хавсралтаар баталсан босго үнийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

7. Эрх бүхий албан тушаалтан нь бүх нийтийн амралтын өдөр буюу 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс 07 дугаар сарын 18-ны өдрүүдэд орон нутагт наадмын нээлтийн арга хэмжээнд оролцоход 9,878.3 мянган төгрөг, Ажлын албан албан тушаалтан нь орон нутагт

ажиллахад 1,360.0 мянган төгрөг, нийт 10,014.3 мянган төгрөгийг дотоод томилолтын зардлаас төсвийг үрэлгэн зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасныг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үрэлгэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1.Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: ГБХНХЯ-ны орон тоо бүтцийг шинэчлэн, дотоод ажил зохион байгуулагчийн орон тоо хасагдсан боловч гэрээт ажилтан ажиллуулж, 10,000.0 мянган төгрөгийн ажлын хөлс олгосон нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "4.1.3.үр ашигтай байх;", Засгийн газрын 2025 оны "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" 07 дугаар тогтоол, ГБХНХЯ-ны ТНБД-ын "Яамны бүтэц, зохион байгуулалтын нэгжийг шинэчлэн батлах тухай" 2025 оны 07 дугаар сарын 18-ны А/218 дугаар тушаалтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын тогтоолоор баталсан орон тооны хязгаарыг мөрдөж, чиг үүрэг нь хасагдсан орон тоонд гэрээт болон түр ажилтан ажиллуулахгүй байх зөвлөмж өгөв.

#### 2.Бараа материалын дансны бүртгэлтэй холбоотой

Илрүүлэлт 2: Албан хаагчдын дотоод ажлын "Эйбл" системийн ашиглах эрх бүхий лицензийн төлбөрт 15,000.0 мянган төгрөг шилжүүлж, шууд зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Лицензийг бараа материалын дансанд бүртгэж, ашиглалтын хугацаа дуусахад зардлаар хүлээн зөвшөөрөх.

#### 3.Худалдан авах ажиллагаатай холбоотой

Илрүүлэлт 3: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй, төлөвлөгөөнд тусгасан дүнгээс 8,232.5 мянган төгрөгөөр илүү барааны /салбарын тэргүүний ажилтны тэмдэг/ худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална." 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 41 дүгээр зүйлийн 41.1-т "Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна", 41.1.1-т "энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан", Төсвийн тухай хуулийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж, худалдан авалтыг зохион байгуулж хэвших зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Нийгмийн даатгалын шимтгэлийн 2,965.1 мянган төгрөгийн илүү төлөлтөөр авлага бүртгэхдээ ерөнхий журналд үндсэн цалингийн зардлыг бууруулсан байна.	1	2,965.1			1	2,965.1	1	2,965.1				
2	Тохируулах бичилтээр 450.0 мянган төгрөгийн худалдан авалтын өглөгийг шууд бичилтээр хаасныг бараа материалын дансанд орлогоор бүртгүүлсэн.	1	450.0			1	450.0	1	450.0				
3	Байгууллагад төлөх 1,895.0 мянган төгрөгийн өглөгийг мөнгөн гүйлгээ, санхүүгийн үр дүнгийн тайланд туслах үйл ажиллагааны орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэн, орлого бууруулах бичилт бичсэн.	1	1,895.0			1	1,895.0	1	1,895.0				
4	Үр дүнгийн тайланд туслах үйл ажиллагааны орлогыг 707.0 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжийн орлогыг 450.0 мянган төгрөгөөр тус тус илүү тайлагнасан.	1	1,157.0			1	1,157.0	1	1,157.0				
5	Машин тоног төхөөрөмжийн элэгдлийн зардлыг 938.6 мянган төгрөгөөр дутуу байгуулсан.	1	938.6	1	938.6			1	938.6				
6	Улсын төсвөөс санхүүжүүлсэн 637,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй "Өгөгдлийн шинжилгээний үйл ажиллагаа" зөвлөх үйлчилгээний урьдчилгаа төлбөр 505,600.0 мянган төгрөгийн мэдээлэл технологийн зардлыг шууд зардалд бүртгэсэн.	1	505,600.0	1	505,600.0			1	505,600.0				
	<b>ДҮН</b>	<b>6</b>	<b>513,005.7</b>	<b>2</b>	<b>506,538.6</b>	<b>4</b>	<b>6,467.1</b>	<b>6</b>	<b>513,005.7</b>			-	-

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Үйл ажиллагааны чиглэл өөр аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан, нийт 56,030.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.	1	56,030.0			1	56,030.0						
2	Анхан шатны бүрдэл дутуу баримтаар нийт 35,810.1 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн байна. Үүнд: 1.Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 1 автотээврийн хэрэгсэлд 2025 оны 05 дугаар сард 23,255.6 мянган төгрөгийн засвар үйлчилгээг хийлгэсэн боловч Өмч хамгаалах зөвлөлийн хурлыг 2025 оны 11 дүгээр сард хуралдуулан засвар хийх шийдвэрийг баталгаажуулсан байна. 2. Хуулийн төслийг олон нийтэд сурталчлах, мэдээлэх салбарын мэргэжилтэн, сэтгүүлчдийн хооронд уулзалт зохион байгуулах хөлсөөр ажиллах гэрээгээр гүйцэтгэх ажил нь хавсралтад заасан ажил хоорондоо зөрүүтэй, гүйцэтгэсэн ажлын тайлангүй, гэрээ дүгнэсэн актгүй, үйл ажиллагааны чиглэл таарахгүй аж ахуй нэгжид урьдчилгаа төлбөр 1,563.5 мянган төгрөгийг олгосон. 3. ГБХНХС-ын 2025 оны "Томилолтоор ажиллуулах тухай" А/33 тоот тушаалын дагуу сайдын орон тооны зөвлөхийн БНСУ-с дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын төвийн үйл ажиллагаатай танилцах гадаад томилолтын зардалд зарцуулсан 10,991.5 мянган төгрөгийн анхан шатны баримт дутуу бүрдүүлж олгосон.	1	35,810.1			1	35,810.1						
3	Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж нийт 76,068.7 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнд: 1. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн "Мөнгөн урамшуулал олгох тухай" А/206 дугаар тушаалаар нэр бүхий 17 ажилтанд салбарын эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажилд идэвхи санаачилгатай ажилласан үндэслэлээр 41,507.0 мянган төгрөгийн шагналыг цалингийн зардлаас олгосон; 2. Засгийн газрын байрны нийтлэг үйлчилгээний газартай байгуулсан гэрээгээр төлөх гэрэл цахилгаан, түлш халаалтын зардлын 14,882.2 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	1	76,068.7			1	76,068.7						

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	хураамжаас төлсөн; 3. Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс худалдан авах зардлаас 1,001.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн. 4. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/69 тоот тушаалын дагуу Бүгд Найрамдах Чех, Бүгд Найрамдах Польш улсад төрийн өндөр хэмжээний айлчлалын бүрэлдэхүүнд ажилласан албан хаагчдын томилолтын зардал 8,000.0 мянган төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас, Катар улсын Доха хотод зохион байгуулагдсан Нийгмийн хөгжлийн төлөөх Дэлхийн дээд хэмжээний II дугаар уулзалтад оролцсон албан хаагчийн замын зардал 2,406.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас зарцуулсан; 5. Мэдээлэл технологийн зардлаас дэлгэцийн түрээс, суурилуулалтын зардалд 6,600.0 мянган төгрөгийг, гэрээт ажилтны цалингийн зардалд 1,672.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.											
4	Батлагдсан төсөвт тусгаагүй ажил үйлчилгээг санхүүжүүлж, 131,470.1 мянган төгрөгийн төсвийг үрэлгэн зарцуулсан байна. Үүнд: 1. ГБХНХСайдын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн " Гэр бүл хөгжил, хамгаалал хөтөлбөрөөс санхүүжих арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай" А/63 дугаар тушаалын хавсралтад өөрчлөлт оруулж, гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрчлэгчдэд сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор 2 сэтгэл зүйч хөлсөөр ажиллуулах гэрээгээр ажиллуулан 30,000.0 мянган төгрөгийн ажлын хөлс олгосон; 2. ГБХНХЯ-ны хэрэгжүүлж байгаа Азийн хөгжлийн банкны "L3605/G9191:МОН-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв"-ийн барилгын газар чөлөөлөхөд 1 иргэнд 18,691.2 мянган төгрөгийн нөхөн олговор олгосон; 3. МУ-д Хүүхдийн байгууллага, хөдөлгөөн үүсэж, хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээнд зориулж, яамны үндсэн үйл ажиллагааны хөтөлбөр арга хэмжээнээс 82,779.0 мянган төгрөгийн зарцуулж, тайлагнасан.	1	131,470.2			1	131,470.2					

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5	<p>Гэрээний үүргийн биелэлт хангалтгүй байхад ажлын тайланг хүлээн авч, нийт 64,500.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгож, төсвийг үрэлгэн байна. Үүнд: 1. Архивын улсын үзлэгт зориулан "Өрнөх бэлийнхэн" ХХК-тай 19,500.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж гэрээнд 2019-2025 оныг дуусталх хугацааны 1000 хадгаламжийн нэгжийг "Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгнө" гэж заасан боловч гэрээ гүйцэтгэсэн ажлын тайланд зөвхөн 2019, 2020 оны архивын баримтыг цэгцлэн хүлээлгэн өгсөн байна. 2. Монгол Улсын 21 аймгийн хөгжлийн бэрхшээлтэй 630 хүүхдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар төлөвлөснөөс 378 хүүхдийг хамруулж, 252 хүүхдийг хамруулаагүй байхад 19,900.0 мянган төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч "Эрхэм нандин сувд" ХХК-д бүрэн олгосон байна. 3. "Аялгуу хөг эгшиг" ХХК-тай байгуулсан 5,200.0 мянган төгрөгийн 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 02/54 тоот гэрээнд гүйцэтгэгч байгууллагын хийх ажил тодорхойгүй, гүйцэтгэгчийн ажлын тайланд хийж гүйцэтгэсэн ажлыг тодорхой тусгаагүй байна. 4. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн "Хэлэлцүүлэг зохион байгуулах тухай" 103 дугаар тушаалаар "Туушин зочид буудал" ХХК-д зохион байгуулсан "Хүүхдийн зуслангийн хөгжлийн бодлого, тогтолцооны шинэчлэл" хэлэлцүүлэгт зарцуулсан 19,650.0 мянган төгрөгийн гэрээт ажлын тайланд хүрсэн үр дүнг бодитой хэмжигдэхүйц байдлаар тайлагнаагүй, гаргасан шийдэл тодорхойгүй байна.</p>	1	64,500.0			1	64,500.0					
6	<p>Тайлант хугацаанд бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болголтгүй 319,082.5 мянган төгрөгийн нэг төрлийн ижил бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийг хуваан шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн. Үүнд: 1. Тайлан онд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийн хэлэлцүүлэг зохион байгуулах тухай " А/21 дүгээр тушаалын дагуу салбарын ажилтнуудад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг танилцуулж, санал авах,</p>	1	319,082.5			1	319,082.5					

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	2025 онд хэрэгжүүлэх Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнүүдийг танилцуулж, арга зүйн заавраар хангах хэлэлцүүлэг, сургалтыг зохион байгуулах ажилд 95,900,000.00 (ерөн таван сая есөн зуун мянган) төгрөгийн зарцуулж, нэг хуулийн этгээдээс шууд худалдан авалт хийсэн; 2.Салбарын үйл ажиллагааг ярилцлага, мэдээ тодруулга, сурвалжлаг видео контент постер хэлбэрээр олон нийтэд сурталчлах ажлын зардал 192,530.5 мянган төгрөгийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлаагүй, тендер сонгон шалгаруулалт зохион байгуулалгүй батлагдсан төсөвт өртгийг хуваан тус бүр нь 4,900.0-18,000.0 мянган төгрөгөөр 29 хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй шууд гэрээ байгуулсан; 3. Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн бэлтгэл ажлын зардал 30,652.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.												
7	ГБХНХЯ-ны орон тоо бүтцийг шинэчлэн, дотоод ажил зохион байгуулагчийн орон тоо хасагдсан боловч гэрээт ажилтан ажиллуулж, 10,000.0 мянган төгрөгийн ажлын хөлс олгосон байна.	1	10,000.0							1	10,000.0		
8	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй, төлөвлөгөөнд тусгасан дүнгээс 8,232.5 мянган төгрөгөөр илүү бараа /салбарын тэргүүний ажилтны тэмдэг/ худалдан авсан.	1	8,232.5							1	8,232.5		
9	Албан хаагчдын дотоод ажлын "Эйбл" системийн ашиглах эрх бүхий лицензийн төлбөрт 15,000.0 мянган төгрөг шилжүүлж, шууд зардалд бүртгэсэн байна.	1	15,000.0							1	15,000.0		
10	Засгийн газрын 2025 оны "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" 07 дугаар тогтоолын дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн "Бүтэц орон тоо шинэчлэн батлах тухай" А/218 дугаар тушаалаар яамны бүтцийг 7 газар, 5 хэлтэс, нийт 125 орон тоотой болгож, 9 хувиар бууруулан баталсан ч хуучин бүтцээр 2025 оны 10 дугаар сарыг дуустал ажилласан байна.	1	-							1	-		

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

11	Эрх бүхий албан тушаалтан нь бүх нийтийн амралтын өдөр буюу 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс 07 дугаар сарын 18-ны өдрүүдэд орон нутагт наадмын нээлтийн арга хэмжээнд оролцоход 9,878.3 мянган төгрөг, ажлын албаны албан тушаалтан нь орон нутагт ажиллахад 1,360.0 мянган төгрөг, нийт 10,014.3 мянган төгрөгийг дотоод томилолтын зардлаас төсвийг үрэлгэн зарцуулсан байна.	1	10,014.3			1	10,014.3						
<b>ДҮН</b>		<b>11</b>	<b>726,208.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>7</b>	<b>692,975.8</b>			<b>4</b>	<b>33,232.5</b>	<b>-</b>	<b>-</b>

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлын нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Шилэн дансны тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>													
1	Шилэн дансны цахим системд байршуулбал зохих байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээллийг 2 удаа, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээтэй холбоотой 97,598.5 мянган төгрөгийн 6 тушаалыг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	97,598.5			1	97,598.5	-	-				
	<b>ДҮН</b>	<b>1</b>	<b>97,598.5</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>97,598.5</b>	<b>-</b>	<b>-</b>				
<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой</i>													
1	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/72 дугаар тушаалыг хэрэгжүүлэхдээ 7 аж ахуйн нэгжээс 82,163.5 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс бэлтгэсэн, дээрх үйл ажиллагааны урилга хэвлүүлэхэд 4,335.0 мянган төгрөг, мэндчилгээ хэвлүүлэхэд 2,182.0 мянган төгрөг, мөн "Засгийн газрын цом-2025" спортын арга хэмжээнд зориулж спорт заалны түрээсийн төлбөрт 1,000.0 мянган төгрөг, нийт 89,680.0 мянган төгрөгөөр төсвийг үрэлгэн зарцуулсан.	1	89,680.5			1	89,680.5						
2	Засгийн газрын 2025 оны "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" 07 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт "Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-т заасан үндсэн чиг үүрэг бүхий ажлуудыг аж ахуй нэгж, хувь хүнтэй "Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ", "Ажил гүйцэтгэх гэрээ" байгуулан нийт 114,800.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон ч үр дүнг тооцоогүй, зөвлөх үйлчилгээ авсны давуу тал, тэдгээрээс гарсан бүтээгдэхүүнийг үйл ажиллагаандаа хэрхэн ашиглаж, нэвтрүүлж байгаа талаар дүгнэлт, тайлан гаргаагүй байна. Үүнд: 1. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг	1	114,800.0			1	114,800.0						

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	<p>боловсруулахтай холбогдуулан судалгаа, шинжилгээ хийж, ажлын хэсэгтэй хамтран ажиллах гэрээний дагуу 14,500.0 мянган төгрөг;</p> <p>2. ГБХНХСалбарын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны тухай, Хүүхэд хамгааллын тухай хууль, түүнтэй холбоотой шинээр боловсруулсан дүрэм журмын төслийг хянах зөвлөх үйлчилгээ үзүүлэх төлбөрт 9,000.0 мянган төгрөг;</p> <p>3. Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төсөл, төслийн бүрдүүлбэрийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу боловсруулах ажлын төлбөрт 14,400.0 мянган төгрөг;</p> <p>4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийн сангийн ажлын даалгавар боловсруулах зөвлөх үйлчилгээний төлбөрт 15,000.0 мянган төгрөг;</p> <p>5. Хуримтлалын сангийн мэдээллийн нэгдсэн системийн ерөнхий бүтцийн санал, санхүүгийн системийн иргэний хүсэлт, өргөдөл гомдол шийдвэрлэх системийн ажлын даалгавар гүйцэтгэх ажлын төлбөрт 15,000.0 мянган төгрөг;</p> <p>6. Гэр бүлийн цогц үйлчилгээний төвийн жишиг загвар төв байгуулах алхамчилсан зураглал боловсруулах, санал зөвлөмж гаргах ажлын хөлсөд 19,900.0 мянган төгрөг;</p> <p>7. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөний үнэлгээ болон хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх ажлын төлбөрт 15,000.0 мянган төгрөг;</p> <p>8. "Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай" 129 дүгээр конвенц, "Аж үйлдвэр, худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай" 147 оны 81 дүгээр конвенц, хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажлын төлбөрт 12,000.0 мянган төгрөгийг тус тус төлсөн байна.</p>											
3	Төрийн аудитын байгууллагад 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэг "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна"-г заасны дагуу иж бүрэн ирүүлээгүй.	1	-						1	-		
4	ГБХНХЯам нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ 2017 оноос хойш хууль, тогтоомж, журамтай нийцүүлэн шинэчлээгүй байна.	1	-						1	-		
	<b>ДҮН</b>	<b>4</b>	<b>204,480.5</b>			<b>2</b>	<b>204,480.5</b>		<b>2</b>	<b>-</b>		
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>5</b>	<b>302,079.0</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>302,079.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 284/А0175347

Улаанбаатар хот

САГ-2026/72/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагааны чиглэл нь өөр аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан, нийт 56,030,000.00 (тавин зургаан сая гучин мянган) төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

1. Хөдөө аж ахуйн сэтгүүлчдийн ур чадвар, чадавхыг дээшлүүлэх, хөдөө аж ахуйн салбарын мэдээ, мэдээллийг мэргэжлийн түвшинд хүртээмжтэйгээр олон нийтэд сурталчлах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл бүхий нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагаас 980,000.00 (есөн зуун наян мянган) төгрөгийн дуу хураагуур худалдан авсан, мөн "Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдэлээс ангид байх, ёс зүйн, шударга байдлыг уриалсан агуулга бүхий видео контент" бэлтгэх ажлыг гэрээгээр гүйцэтгүүлж 12,000,000.00 (арван хоёр сая) төгрөгийг олгосон;
2. Төрийн албаны өдрийг угтан зохион байгуулах Эрдэм шинжилгээний хуралд зориулж 5,200,000.0 (таван сая хоёр зуун мянган) төгрөгөөр 371 ширхэг тараах материал бэлтгэн хэвлүүлэх ажлыг Хөгжлийн бэрхшээлтэй, хүнд өвчтэй хүүхдүүдэд болон асран хамгаалагч нарт сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, бүх талын туслалцаа, дэмжлэг үзүүлэх чиглэл бүхий аж ахуй нэгжээр гүйцэтгүүлсэн;
3. Хэвлэлийн үйл ажиллагаа эрхэлдэггүй аж ахуй нэгжтэй гэрээ байгуулж, сургалтын тараах материал хэвлүүлэх зардалд 37,850,000.00 (гучин долоон сая найман зуун тавин мянган) төгрөгийг тус тус зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх," гэж тус тус заасныг зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.9-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үйл ажиллагааны чиглэл нь өөр аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан санхүүжилт олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Мөнхзул/, Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга /Д.Мөнгөнтуул/, Яамны санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Г.Баасансүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ  
Д.НОМИНГУА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 285/АО/75347

Улаанбаатар хот

САГ-2026/72/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:  
Анхан шатны бүрдэл дутуу баримтаар нийт 35,810,100.00 (гучин таван сая найман зуун арван мянга нэг зуун) төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 1 автотээврийн хэрэгсэлд 2025 оны 05 дугаар сард 23,255,600.00 (хорин гурван сая хоёр зуун тавин таван мянга зургаан зуун) төгрөгийн засвар үйлчилгээг хийлгэсэн боловч Өмч хамгаалах зөвлөлийн хурлыг 2025 оны 11 дүгээр сард хуралдуулан, шийдвэрийг засвар хийснээс хойш баталгаажуулсан;
2. Хуулийн төслийг олон нийтэд сурталчлах, мэдээллэх, "салбарын мэргэжилтэн, сэтгүүлчдийн хооронд уулзалт зохион байгуулах гэрээ"-ний ерөнхий зүйлд заасан ажил, хавсралтад заасан ажил хоорондоо зөрүүтэй, гүйцэтгэсэн ажлын тайлангүй, гэрээ дүгнэсэн актгүй, үйл ажиллагааны чиглэл нь өөр аж ахуй нэгжид ажлын төлбөр 1,563,500.00 (нэг сая таван зуун жаран гурван мянган таван зуун) төгрөгийг олгосон;
3. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны "Томилолтоор ажиллуулах тухай" А/33 тоот тушаалын дагуу сайдын орон тооны зөвлөхийн Бүгд Найрамдах Солонгос Улс дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын төвийн үйл ажиллагаатай танилцах гадаад томилолтын зардалд зарцуулсан 10,991,500.0 (арван сая есөн зуун ерэн нэгэн мянга таван зуун) төгрөгийг анхан шатны баримт дутуу бүрдүүлж олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасныг тус тус зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-44.Docx

1526180696

өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Мөнхзул/, Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга /Д.Мөнгөнтуул/, Яамны санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Г.Баасансүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ  
Д.НОМИНГУА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 286/А0175347

Улаанбаатар хот

(АГ-2026/72/НА-СТА-ТШЗ)

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд: Тайлант онд зардлын эдийн засгийн ангилал зөрчиж, нийт 76,068,700.00 (далан зургаан сая жаран найман мянга долоон зуун) төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

1. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн "Мөнгөн урамшуулал олгох тухай" А/206 дугаар тушаалаар нэр бүхий 17 ажилтанд салбарын эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажилд идэвхи санаачлагатай ажилласан үндэслэлээр 41,507,000.00 (дөчин нэгэн сая таван зуун долоон мянган) төгрөгийн шагналыг цалингийн зардлаас олгосон;
2. Засгийн газрын байрны нийтлэг үйлчилгээний газартай байгуулсан гэрээгээр төлөх гэрэл цахилгаан, түлш халаалтын зардлын 14,882,200.00 (арван дөрвөн сая найман зуун наян хоёр мянга хоёр зуун) төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжаас төлсөн;
3. Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс худалдан авах зардлаас 1,001,000.00 (нэг сая нэг мянган) төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн;
4. Төрийн нарийн бичгийн даргын 2025 ны А/69 тоот тушаалын дагуу Бүгд Найрамдах Чех, Бүгд Найрамдах Польш улсад төрийн өндөр хэмжээний айлчлалын бүрэлдэхүүнд ажилласан албан хаагчдын гадаад томилолтын зардлын 8,000,000.00 (найман сая) төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас, Катар улсын Доха хотод зохион байгуулагдсан Нийгмийн хөгжлийн төлөөх Дэлхийн дээд хэмжээний II дугаар уулзалтад оролцсон албан хаагчийн замын зардлын 2,406,000.00 (хоёр сая дөрвөн зуун зургаан мянган) төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас зарцуулсан;
5. Мэдээлэл технологийн зардлаас дэлгэцийн түрээс, суурилуулалтын зардалд 6,600,000.00 (зургаан сая зургаан зуун мянган) төгрөгийг, гэрээт ажилтны цалингийн зардалд 1,672,500.00 (нэг сая зургаан зуун далан хоёр мянга таван зуун) төгрөгийг тус тус эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"; Сангийн сайдын 2023 оны "Ангилал шинэчлэн батлах тухай" 211 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал",

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

Z:\Alban Shaardloga\2026\0125 SAG-44.Docx

1526180698

тавдугаар хавсралтын 2 дахь хэсэг “Урсгал зардлын ангиллын тайлбар”-ыг тус тус зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал,” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зардлын эдийн засгийн ангилал зөрчин төсөв зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Мөнхзул/, Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга /Д.Мөнгөнтуул/, Яамны санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Г.Баасансүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ  
Д.НОМИНГУА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 287/А017547

Улаанбаатар хот

САГ-2026/72/НА-СТА-ТЦ13

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсөвт тусгаагүй ажил үйлчилгээг санхүүжүүлж, нийт 131,470,169.00 (Нэг зуун гучин нэгэн сая дөрвөн зуун далан мянга нэг зуун жаран есөн) төгрөгийн төсвийг үрэлгэн зарцуулсан байна. Үүнд:

1. Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн "Гэр бүл хөгжил, хамгаалал хөтөлбөрөөс санхүүжих арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай" А/63 дугаар тушаалын хавсралтад өөрчлөлт оруулж, гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрчлэгчдэд сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор 2 сэтгэл зүйчид хөлсөөр ажиллуулах гэрээгээр байгуулж нийт 30,000,000.00 (гучин сая) төгрөгийн ажлын хөлс олгосон;
2. Азийн хөгжлийн банкны "L3605/G9191:MON-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв"-ийн барилгын газар чөлөөлөхөд нэг иргэнд 18,691,169.00 (арван найман сая зургаан зуун ерэн нэгэн мянга нэг зуун жаран есөн) төгрөгийн нөхөн олговрыг олгосон;
3. Монгол Улсад Хүүхдийн байгууллага, Хөдөлгөөн үүсэж, хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээнд зориулж, яамны үндсэн үйл ажиллагааны хөтөлбөр арга хэмжээнээс 82,779,000.00 (наян хоёр сая долоон зуун далан есөн мянган) төгрөгийг тус тус зарцуулсан.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх," 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан," гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсөвт тусгаагүй ажил үйлчилгээг санхүүжүүлж, төсвийг үрэлгэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Мөнхзул/, Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга /Д.Мөнгөнтуул/, Яамны санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Г.Баасансүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ  
Д.НОМИНГУА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 288/А0175347  
САГ-2026/72/НА-СТА-ТШ13

Улаанбаатар хот

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гэрээний үүргийн биелэлт хангалтгүй байхад ажлын тайланг хүлээн авч, нийт 64,500,000.00 (жаран дөрвөн сая таван зуун мянган) төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгож, төсвийг үрэлгэн зарцуулсан:

1. Архивын улсын үзлэгт зориулан 19,500,000.00 (арван есөн сая таван зуун мянган) төгрөгийн гэрээ байгуулж, гэрээнд 2019-2025 оныг дуусталх хугацааны 1,000 хадгаламжийн нэгжийг "Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгнө" гэж заасан боловч гэрээ гүйцэтгэсэн ажлын тайланд зөвхөн 2019, 2020 оны архивын баримтыг цэгцлэн хүлээлгэн өгч, 2021-2025 оны баримтыг хүлээлгэн өгөөгүй;
2. Монгол Улсын 21 аймгийн хөгжлийн бэрхшээлтэй 630 хүүхдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар төлөвлөснөөс 378 хүүхдийг хамруулж, 252 хүүхдийг хамруулаагүй байхад 19,900,000.00 (арван есөн сая есөн зуун мянган) төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид бүрэн олгосон;
3. Хуулийн этгээдтэй байгуулсан 5,500,000.00 (таван сая таван зуун мянган) төгрөгийн өртөгтэй "Ажил гүйцэтгэх гэрээ"-нд гүйцэтгэгч байгууллагын хийх ажил тодорхойгүй, гүйцэтгэгчийн ажлын тайланд хийж гүйцэтгэсэн ажлын талаар тодорхой тусгаагүй;
4. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн "Хэлэлцүүлэг зохион байгуулах тухай" А/103 дугаар тушаалаар зохион байгуулсан "Хүүхдийн зуслангийн хөгжлийн бодлого, тогтолцооны шинэчлэл" хэлэлцүүлэгт зарцуулсан 19,600,000.00 (арван есөн сая зургаан зуун тавин мянган) төгрөгийн гэрээт ажлын тайланд хүрсэн үр дүнг бодитой хэмжигдэхүйц байдлаар тайлагнаагүй, гаргасан шийдэл тодорхойгүй;


Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасныг тус тус зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.4-д “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй, эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн;” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний үүргийн биелэлт хангалтгүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийж төсвийг үрэлгэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Мөнхзул/, Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга /Д.Мөнгөнтуул/, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Г.Баасансүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ  
Д.НОМИНГУА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 289/АД175347

Улаанбаатар хот

САГ - 2026/72/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/72 дугаар тушаалыг хэрэгжүүлэхдээ 7 аж ахуйн нэгжээс 82,163,500.00 (наян хоёр сая нэг зуун жаран гурван мянга таван зуун) төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс бэлтгэсэн, дээрх үйл ажиллагааны урилга хэвлүүлэхэд 4,335,000.00 (дөрвөн сая гурван зуун гучин таван мянган) төгрөг, мэндчилгээ хэвлүүлэхэд 2,182,000.00 (хоёр сая нэг зуун наян хоёр мянган) төгрөг, мөн "Засгийн газрын цом-2025" спортын арга хэмжээнд зориулж спорт заалны түрээсийн төлбөрт 1,000,000.00 (нэг сая) төгрөг, нийт 89,680,500.00 (наян есөн сая зургаан зуун наян мянга таван зуун) төгрөгөөр төсвийг үрэлгэн зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;", 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах." гэж заасныг тус тус зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-д "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй, эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн хууль зөрчиж, бэлэг дурсгалын зүйлс бэлтгэсэн, спортын арга хэмжээнд зориулж төсвийг үрэлгэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Мөнхзул/, Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга /Д.Мөнгөнтуул/, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Г.Баасансүрэн/ нэрт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ  
Д.НОМИНГУА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-44.Docx

1526180933



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 290/А0175347

Улаанбаатар хот

САГ - 2026 / 72 / НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрх бүхий албан тушаалтан нь бүх нийтийн амралтын өдөр буюу 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс 07 дугаар сарын 18-ны өдрүүдэд орон нутагт наадмын нээлтийн арга хэмжээнд оролцоход 9,878,330.00 (есөн сая найман зуун далан найман мянга гурван зуун гучин) төгрөг, ажлын албаны албан тушаалтан нь орон нутагт ажиллахад 1,360,000.00 (нэг сая гурван зуун жаран мянган) төгрөг, нийт 10,014,330.00 (арван сая арван дөрвөн мянга гурван зуун гучин) төгрөгийг дотоод томилолтын зардлаас төсвийг үрэлгэн зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасныг тус тус зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-д "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй, эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үрэлгэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Мөнхзул/, Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга /Д.Мөнгөнтуул/, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Г.Баасансүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ  
Д.НОМИНГУА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

Z: Alban-Shaardlaga\2026\0125-SAG-J4.Docx

1526180931



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 291/А0175347

Улаанбаатар хот

САГ-2026/72/НА-СТА-ТЦУЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын 2025 оны "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" 07 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт "Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-т заасан үндсэн чиг үүрэг бүхий ажлуудыг аж ахуй нэгж, хувь хүнтэй "Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ", "Ажил гүйцэтгэх гэрээ" байгуулан нийт 114,800,000.00 (нэг зуун арван дөрвөн сая найман зуун мянган) төгрөгийн санхүүжилт олгосон ч үр дүнг тооцоогүй, зөвлөх үйлчилгээ авсны давуу тал, тэдгээрээс гарсан бүтээгдэхүүнийг үйл ажиллагаандаа хэрхэн ашиглаж, нэвтрүүлж байгаа талаар дүгнэлт, тайлан гаргаагүй байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахтай холбогдуулан судалгаа, шинжилгээ хийж, ажлын хэсэгтэй хамтран ажиллах гэрээний дагуу 14,500,000.00 (арван дөрвөн сая таван зуун мянган) төгрөг;
2. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны тухай, Хүүхэд хамгааллын тухай хууль, түүнтэй холбоотой шинээр боловсруулсан дүрэм журмын төслийг хянах зөвлөх үйлчилгээ үзүүлэх төлбөрт 9,000,000.00 (есөн сая) төгрөг;
3. Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төсөл төслийн бүрдүүлбэрийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу боловсруулах ажлын төлбөрт 14,400,000.00 (арван дөрвөн сая дөрвөн зуун мянган) төгрөг;
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийн сангийн ажлын даалгавар боловсруулах зөвлөх үйлчилгээний төлбөрт 15,000,000.00 (арван таван сая) төгрөг;
5. Хуримтлалын сангийн мэдээллийн нэгдсэн системийн ерөнхий бүтцийн санал, санхүүгийн системийн иргэний хүсэлт, өргөдөл гомдол шийдвэрлэх системийн ажлын даалгавар гүйцэтгэх ажлын төлбөрт 15,000,000.0 (арван таван сая) төгрөг;
6. Гэр бүлийн цогц үйлчилгээний төвийн жишиг загвар төв байгуулах алхамчилсан зураглал боловсруулах, санал зөвлөмж гаргах ажлын хөлсөд 19,900,000.00 (арван есөн сая есөн зуун мянган) төгрөг;
7. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөний үнэлгээ болон хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх ажлын төлбөрт 15,000,000.00 (арван таван сая) төгрөг;
8. "Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай" 129 дүгээр конвенц, "Аж үйлдвэр, худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай" 147 оны 81 дүгээр конвенц, хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажлын төлбөрт 12,000,000.00 (арван хоёр сая) төгрөгийг тус тус төлсөн байна.

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

Z:\Alhan Shaardlaga\2026\0125 SAG-44.Docx

1526180941


Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"; Засгийн газрын 2025 оны "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" 07 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт "Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-т тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-д "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй, эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөвлөх ажил үйлчилгээний давуу тал болон үр дүнг тооцоогүй, тэдгээрээс гарсан бүтээгдэхүүнийг үйл ажиллагаандаа хэрхэн ашиглаж, нэвтрүүлж байгаа талаар дүгнэлт, тайлан гаргаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Мөнхзул/, Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга /Д.Мөнгөнтуул/, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Г.Баасансүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ  
Д.НОМИНГУА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 292/ АО 175347  
САГ-2026/72/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим системд байршуулбал зохих байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээллийг 2 удаа, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мөнгө зарцуулахтай холбоотой 97,598,500.00 (ерөн долоон сая таван зуун ерөн найман мянга таван зуун) төгрөгийн 6 тушаалыг хугацаа хоцроож байршуулсан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна:", 3.1.1-д "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд:", 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр:", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуульд заасан цаглаварт хугацаанд мэдээллийг бүрэн байршуулаагүй, хугацаа хоцроосон мэдээлдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Мөнхзул/, Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга /Д.Мөнгөнтуул/, Яамны санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Г.Баасансүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ  
Д.НОМИНГУА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй бүсрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-26-230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-44.Docx

1526180712



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 293/А0175347

Улаанбаатар хот

САГ - 2026/72/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд: Тайлант онд худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, нийт 319,082,500.00 (гурван зуун арван есөн сая наян хоёр мянга таван зуун) төгрөгийн дараах ажил, үйлчилгээг шууд худалдан авалт хийсэн. Үүнд:

- Тайлан онд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийн хэлэлцүүлэг зохион байгуулах тухай" А/21 дүгээр тушаалын дагуу салбарын ажилтнуудад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг танилцуулж, санал авах, 2025 онд хэрэгжүүлэх Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнүүдийг танилцуулж, арга зүйн заавраар хангах хэлэлцүүлэг, сургалтыг зохион байгуулах ажилд 95,900,000.00 (ерэн таван сая есөн зуун мянган) төгрөгийн зарцуулж, нэг хуулийн этгээдээс шууд худалдан авалт хийсэн;
- Салбарын үйл ажиллагааг ярилцлага, мэдээ тодруулга, сурвалжлага видео контент постер хэлбэрээр олон нийтэд сурталчлах ажлын зардал 192,530,500.00 (нэг зуун ерэн хоёр сая таван зуун гучин мянга таван зуун) төгрөгийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлаагүй, тендер сонгон шалгаруулалт зохион байгуулалгүй батлагдсан төсөвт өртгийг хуваан тус бүр нь 4,900.0-18,000.0 төгрөгөөр 29 хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй шууд гэрээ байгуулсан;
- Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн бэлтгэл ажлын зардал 30,652,000.0 (гучин сая зургаан зуун тавин хоёр мянган) төгрөгийг тус тус зарцуулсан байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.", Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 2 дугаар тогтоолын хавсралтаар баталсан босго үнийг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.9.-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол;” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Мөнхзул/, Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга /Д.Мөнгөнтуул/, Яамны санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Г.Баасансүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ  
Д.НОМИНГУА